

БНМАУ-ЫН ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙН ЯАМНЫ КОЛЛЕГИ,
УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ.

1983 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 210/160 Улаанбаатар
хот.

АБХГЗ-ны 1989 оны 161 тоот

Шинэ дэлгүүр нээн ажиллуулах тухай.

БНМАУ-ын Худалдаа бэлтгэлийн яамны коллеги, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар баригдаж ашиглалтад орж байгаа 3-4 дүгээр хорооллын тус бүр 15 худалдагчийн ажлын байртай 4 дэлгүүрийг хүнс, ХАА, гутал, сүлжмэлийн барааны төрөлжсөн дэлгүүрээр энэ оны 9 дүгээр сарын I-нээс эхлэн нээн ажиллуулсугай.

2.Дээрх дэлгүүрийн орон тоог хавсралтаар баталсугай.

3.Хүнсний барааны 70 дугаар дэлгүүрт архи, пиво худалдаалахыг зогсоож, шинээр орж байгаа хүнсний барааны дэлгүүрт худалдаалахыг Худалдаа удирдах газар /н.ШАГДАР/-т зөвшөөрсүгэй.

4.Энэ дэлгүүрийн тоног төхөөрөмжийн засварыг хариуцахыг Худалдааны төхөөрөмжийн засвар, зарлал чимэглэлийн газар /н.НАМСРАЙ/-т, БНМАУ-ын Ардын Их Хурлын худалдаа, үйлчилгээний байнгын комиссын 1983 оны 4 тоот зөвлөмжийн дагуу тоног төхөөрөмжийн засварын удирдлагыг төвлөрүүлэх зорилгоор 100 дугаар дэлгүүрийн тоног төхөөрөмжийн механикч нэг, слесарьч нэг, 56 дугаар дэлгүүрийн тоног төхөөрөмжийн механикч нэг нийт 3 орон тоог энэ 9 дүгээр сарын I-нээр тасалбар болгон цалингийн фондын хамт Худалдааны

төхөөрөмжийн засвар, зарлал чимэглэлийн газарт шилжүүлэхийг Худалдаа удирдах газар /н.ШАГДАР/-т даалгасугай.

5.Мөн зөвлөмжийн дагуу Нармагт дөрөв, зургаан худалдагчийн ажлын байртай дэлгүүрийн зураг төсвийг 1983 онд гаргаж 1984 онд барих, Нисэхэд 4 худалдагчийн ажлын байртай дэлгүүр, 29 дүгээр дэлгүүрийн өргөтгөлийн зураг төсвийг 1984 онд хийж 1985 онд барихыг Барилга архитектур төлөвлөлтийн газар /н.ЖАДАМБАА/, Барилга засварын контор /н.ЖИГМЭД/-т даалгасугай.

БНМАУ-ЫН ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙН
ЯАМНЫ САЙД

Ч.МОЛОМ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ҮН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

38

БНМАУ-ын Худалдаа бэлтгэлийн яамны коллег, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1983 оны 210/160 тоот тогтоолын хавсралт.

**3-4 ДҮГЭЭР ХОРООЛОЛД ШИНЭЭР НЭЭГДЭХ ХҮНС,ХАА,
ГУТАЛ, СҮЛЖМЭЛИЙН БАРААНЫ ДЭЛГҮҮРИЙН ШРОН
ТОО.**

Албан тушаал	үүнээс:				
	бүгд	хүнсний бараа	ХАА-н бараа	гутал	сүлжмэлийн бараа
1.Эрхлэгч	2	1	-	1	-
2.Ня-бо	4	1	1	1	1
3.Нярав	9	3	2	2	2
4.Худалдагч	70	25	25	10	10
5.Кассчин	22	7	8	4	3
6.Ачигч	16	6	6	2	2
7.Үйлчлэгч	18	6	6	3	3
8.Мах бэлтгэгч	4	-	4	-	-
9.Манаач	10	3	2	3	2
10.Бохирын цэвэрлэгч	1	1	-	-	-
11.Цахилгаан шат ажил- луулагч	3	2	-	1	-
12.Узелийн слесарь	1	1	-	-	-
13.Салхивчийн слесарь	1	1	-	-	-
14.Сав угаагч	2	-	2	-	-
БҮГД	168	57	56	27	23

Тайлбар: 1.Хүнсний бараа боогч 10-ыг нормын дагуу хийснээр нь цалинжуулна.

2.Хүнс, ХАА-н бараанд нэг, Гутал, бэлэн хувцасны бараанд нэг эрхлэгчийг тус тус ажиллуулна.

3.2 дэлгүүрийн дунд талбайн үйлчлэгч 1 байна.

БНМАУ-ЫН ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙН
ЯАМ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА.